

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Дархан сумын 26 дугаар цэцэрлэг 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2025/91/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Дархан-Уул аймаг  
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр:  
Утас: 70378845  
Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Ахлах аудитор: С.Батцэцэг  
Утас: 70373089  
Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Аудитор: Ч.Мөнхбаяр  
Утас: 89275858  
Цахим хаяг: tsesb.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **АГУУЛГА**

---

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
Асуудлыг онцолсон хэсэг .....	3
Аудитын гол асуудал.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	14
4.1 Ерөнхий зүйл .....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
4.5.1 Завсрын аудитын талаар .....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	18
5.1 Төлбөрийн акт .....	18
5.2 Албан шаардлага.....	19
5.3 Зөвлөмж .....	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	20

### **Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГНХ,ЗДНХөрөнгө	Засгийн газрын нөөц хөрөнгө, Засаг даргын нөөц хөрөнгө
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,  
Дархан-Уул аймаг, 45059.  
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089  
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

ДАРХАН УУЛ АЙМГИЙН 26 ДУГААР  
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
М.ОЮУНБАЯР ТАНАА

2025, 08. 15 № 69

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын 26 дугаар цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант хугацаанд Боловсрол, шинжлэх ухааны яамны хөрөнгө оруулалтаар 11,493.0 мянган төгрөгийн компьютер, ОНХС-ын хөрөнгө оруулалтаар 8,340.0 мянган төгрөгийн аяга таваг угаагч хүлээн авч, үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж, тайлагнасан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг нэмэгдүүлснээр цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардал 498,706.1 мянган төгрөг болж, өнгөрсөн оны гүйцэтгэлээс 46.6 хувиар өссөн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Дархан Уул аймгийн Дархан сумын 26 дугаар цэцэрлэгийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 14 зорилтын хүрээнд 66 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 98 хувиар тайлагнасан байна. Мөн улирал бүр Боловсрол газарт ажлын тайланг хүргүүлж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. □

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ. □

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>99,120,766.15</b>	<b>155,803,959.21</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>70,850,936.75</b>	<b>112,085,132.21</b>
312	Банканд байгаа бэлэн мөнгө	70,850,936.75	112,085,132.21
3121	төгрөг		
31211	Төрийн сангийн харилцах		
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	-	-
332	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	-
3351	Байгууллагаас авах авлага		
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>28,269,829.40</b>	<b>43,718,827.00</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>371,500.00</b>	<b>524,290.00</b>
3511	Тусгай зориулалттай материал	-	-
3513	Эм боох материал	371,500.00	524,290.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>27,898,329.40</b>	<b>43,194,537.00</b>
35410	Бичиг хэргийн материал	673,500.00	689,500.00
35420	Аж ахуйн материал	15,810,600.00	29,554,662.00
35430	Сэлбэг хэрэгсэл	-	-
35440	Түлш, шатах тослох материал	-	-
3545	Барилгын засварын материал	-	-
3546	Хүнсний материал	5,609,229.40	7,145,375.00
35470	Бусад хангамжийн материал	5,805,000.00	5,805,000.00
36	НӨӨЦ БАРАА		
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>879,772,024.15</b>	<b>901,844,121.70</b>
<b>37</b>	<b>УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>		
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>879,772,024.15</b>	<b>901,844,121.70</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>854,572,024.15</b>	<b>867,065,746.72</b>
39201	Барилга, байгууламж орон сууц	900,000,000.00	900,000,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(78,750,000.00)	(93,750,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	47,808,354.30	70,460,168.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(29,536,644.14)	(24,882,595.49)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	31,617,031.46	24,182,736.06
39208	Хуримтлагдсан элэгдэл	(23,370,430.31)	(13,350,536.91)
39214	Бусад үндсэн хөрөнгө	18,615,900.66	18,615,900.66
39215	Хуримтлагдсан элэгдэл	(12,056,687.82)	(14,454,425.60)
39217	Ном	244,500.00	244,500.00
393	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>25,200,000.00</b>	<b>34,778,374.98</b>
39301	Программ хангамж	1,124,300.00	725,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,124,300.00)	(90,625.02)
39303	Бусад биет бус хөрөнгө	25,200,000.00	34,144,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>978,892,790.30</b>	<b>1,057,648,080.91</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>978,892,790.30</b>	<b>1,057,648,080.91</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	978,892,790.30	1,057,648,080.91
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	941,267,564.11	941,267,564.11
51101	Өмч: - төрийн	-	-
512	Хуримтлагдсан үр дүн	37,625,226.19	107,436,516.80
51210	Өмнөх үеийн үр дүн	37,625,226.19	37,625,226.19
51220	Тайлант үеийн үр дүн	-	69,811,290.61
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	-	8,944,000.00
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>978,892,790.30</b>	<b>1,057,648,080.91</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>549,951,063.00</b>	<b>778,859,200.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>8,127,663.00</b>	<b>36,416,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	8,127,663.00	36,416,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		12,523,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	8,127,663.00	23,893,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	-	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>541,823,400.00</b>	<b>742,443,200.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>513,399,400.00</b>	<b>697,146,200.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	513,399,400.00	697,146,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>28,424,000.00</b>	<b>45,297,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /Орон нутгийн төсөвт байгууллага/	28,424,000.00	45,297,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	0.00	0.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>508,644,584.88</b>	<b>709,047,909.39</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>508,644,584.88</b>	<b>709,047,909.39</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>507,254,838.56</b>	<b>692,994,928.64</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>340,022,301.85</b>	<b>498,706,103.20</b>
210101	Үндсэн цалин	218,443,433.61	340,458,352.20
210102	Нэмэгдэл	108,092,648.24	136,761,418.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	0.00
210104	Урамшуулал	13,486,220.00	21,486,333.00
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	0.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>44,529,100.00</b>	<b>60,567,618.34</b>
210201	Тэтгэврийн даатгал	30,262,500.00	41,185,976.47
210202	Тэтгэмжийн даатгал	3,566,600.00	4,845,385.47
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,853,400.00	2,394,524.17
210204	Ажилгүйдлийн даатгал	713,500.00	2,422,692.73
210205	Эрүүл мэндийн даатгал	7,133,100.00	9,719,039.50
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>20,118,253.68</b>	<b>17,098,419.25</b>
210301	Гэрэл, цахилгаан	5,662,329.47	5,600,450.10
210302	Түлш, халаалт	9,421,250.87	6,613,852.08
210303	Цэвэр, бохир ус	5,034,673.34	4,884,117.07
210304	байрны түрээс	-	-

<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>10,372,220.00</b>	<b>7,010,488.00</b>
210401	Бичиг хэрэг	2,275,740.00	4,602,250.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	0.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0.00	196,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,096,480.00	2,211,838.00
210408	Бараа материал акталсны зардал	0.00	0.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>54,311,127.55</b>	<b>62,318,937.40</b>
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	75,010.00	0.00
210502	Хоол, хүнс	54,236,117.55	62,318,937.40
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>6,916,000.00</b>	<b>9,000,000.00</b>
210604	Урсгал засвар	6,916,000.00	9,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,044,800.00</b>	<b>1,905,300.00</b>
210806	мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,044,800.00	1,905,300.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>29,941,035.48</b>	<b>36,388,062.45</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,732,200.00	9,409,260.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	50,000.00	0.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	25,158,835.48	26,978,802.45
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,389,746.32</b>	<b>16,052,980.75</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>0.00</b>	<b>6,854,400.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.00	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		6,854,400.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>1,389,746.32</b>	<b>9,198,580.75</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,389,746.32	9,198,580.75
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>41,306,478.12</b>	<b>69,811,290.61</b>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	0.00	
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	0.00	
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>41,306,478.12</b>	<b>69,811,290.61</b>



2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>541,823,400.00</b>	<b>742,443,200.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	-
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	-
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого		
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>541,823,400.00</b>	<b>742,443,200.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>513,399,400.00</b>	<b>697,146,200.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	513,399,400.00	697,146,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>28,424,000.00</b>	<b>45,297,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	28,424,000.00	45,297,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>486,612,501.85</b>	<b>697,518,104.54</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>486,612,501.85</b>	<b>697,518,104.54</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>485,222,755.53</b>	<b>681,465,123.79</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал</b>	<b>340,022,301.85</b>	<b>498,706,103.20</b>
210101	Үндсэн цалин	218,443,433.61	340,458,352.20
210102	Нэмэгдэл	108,092,648.24	136,761,418.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	0.00
210104	Урамшуулал	13,486,220.00	21,486,333.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	-
<b>2102</b>	<b>Ажил олгогчийн нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>44,529,100.00</b>	<b>60,567,618.34</b>
210201	Тэтгэврийн даатгалын	30,262,500.00	41,185,976.47
210202	Тэтгэмжийн даатгалын	3,566,600.00	4,845,385.47
210203	ҮОМШӨ-ий даатгалын	2,853,400.00	2,394,524.17
210204	Ажилгүйдлийн даатгалын	713,500.00	2,422,692.73
210205	Эрүүл мэндийн даатгалын	7,133,100.00	9,719,039.50
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>20,118,253.68</b>	<b>17,098,419.25</b>
210301	Гэрэл, цахилгаан	5,662,329.47	5,600,450.10
210302	Түлш, халаалт	9,421,250.87	6,613,852.08
210303	Цэвэр, бохир ус	5,034,673.34	4,884,117.07
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материал</b>	<b>7,200.00</b>	<b>196,400.00</b>



210401	Бичиг хэргийн зардал	7,200.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0.00	196,400.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>56,983,800.00</b>	<b>63,855,083.00</b>
210502	Хоол, хүнс	56,983,800.00	63,855,083.00
<b>2106</b>	<b>Эд хогшил урсгал засвар</b>	<b>6,916,000.00</b>	<b>19,000,000.00</b>
210604	Урсгал засвар	6,916,000.00	19,000,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	-	-
210702	Дотоодын томилолт	-	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,044,800.00</b>	<b>1,905,300.00</b>
210806	мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,044,800.00	1,905,300.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>15,601,300.00</b>	<b>20,136,200.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,466,800.00	13,281,800.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	3,134,500.00	6,854,400.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,389,746.32</b>	<b>16,052,980.75</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	<b>6,854,400.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	-	6,854,400.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>1,389,746.32</b>	<b>9,198,580.75</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,389,746.32	9,198,580.75
<b>22</b>	<b>Хөрөнгийн зардал</b>	<b>55,210,898.15</b>	<b>44,925,095.46</b>
<b>2220</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>		
225108	Бусад хөрөнгө	55,210,898.15	
<b>3</b>	<b>Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>55,210,898.15</b>	<b>44,925,095.46</b>
<b>4</b>	<b>Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дүн</b>		
<b>5</b>	<b>Хөрөнгө оруулалтын мөнгөн зарлагын дүн</b>	<b>(27,000.00)</b>	<b>(3,690,900.00)</b>
<b>22</b>	<b>Хөрөнгийн зардал</b>	<b>(27,000.00)</b>	<b>(3,690,900.00)</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>(27,000.00)</b>	<b>(3,690,900.00)</b>
223001	Бусад хөрөнгө	(27,000.00)	3,690,900.00
<b>6</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>		
<b>7</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>8</b>	<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>55,183,898.15</b>	<b>41,234,195.46</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>70,850,936.75</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>112,085,132.21</b>



2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/


Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хурифтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	941,267,564.11	-	(3,681,251.93)	-	937,586,312.18
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл					-
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
C07	Тайлант үеийн үр дүн			41,306,478.12		41,306,478.12
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	941,267,564.11	-	37,625,226.19	-	978,892,790.30
D01	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
D02	Дахин илэрхийлсэн үлдэгдэл					-
D03	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		8,944,000.00			8,944,000.00
D04	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					-
D05	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
D06	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					-
D07	Тайлант үеийн үр дүн			69,811,290.61		69,811,290.61
D08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	941,267,564.11	8,944,000.00	107,436,516.80	-	1,057,648,080.91



## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>2</b>	<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	<b>813,294,100.00</b>	<b>692,010,423.79</b>	<b>(121,283,676.21)</b>	<b>85.09</b>
21	Урсгал зардлын дүн	813,294,100.00	688,319,523.79	(124,974,576.21)	84.63
<b>210</b>	<b>Бараа үйлчилгээний зардал</b>	<b>806,439,700.00</b>	<b>681,465,123.79</b>	<b>(124,974,576.21)</b>	<b>84.50</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>592,154,500.00</b>	<b>498,706,103.20</b>	<b>(93,448,396.80)</b>	<b>84.22</b>
210101	Үндсэн цалин	423,795,600.00	340,458,352.20	(83,337,247.80)	80.34
210102	Нэмэгдэл	159,618,900.00	136,761,418.00	(22,857,482.00)	85.68
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	0.00	-	
210104	Урамшуулал	8,740,000.00	21,486,333.00	12,746,333.00	245.84
210105	Гэрээт ажлын хөлс	-	-	-	
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>69,053,700.00</b>	<b>60,567,618.34</b>	<b>(8,486,081.66)</b>	<b>87.71</b>
210201	Тэтгэврийн даатгал	46,957,800.00	41,185,976.47	(5,771,823.53)	87.71
210202	Тэтгэмжийн даатгал	5,523,000.00	4,845,385.47	(677,614.53)	87.73
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,762,100.00	2,394,524.17	(367,575.83)	86.69
210204	Ажилгүйдлийн даатгал	2,762,100.00	2,422,692.73	(339,407.27)	87.71
210205	ЭМД-ын хураамж	11,048,700.00	9,719,039.50	(1,329,660.50)	87.97
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>26,297,000.00</b>	<b>17,098,419.25</b>	<b>(9,198,580.75)</b>	<b>65.02</b>
210301	Гэрэл, цахилгаан	8,350,000.00	5,600,450.10	(2,749,549.90)	67.07
210302	Түлш, халаалт	9,447,000.00	6,613,852.08	(2,833,147.92)	70.01
210303	Цэвэр, бохир ус	8,500,000.00	4,884,117.07	(3,615,882.93)	57.46
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>-</b>	<b>196,400.00</b>	<b>196,400.00</b>	
210403	Шуудан холбоо	0.00	196,400.00	196,400.00	
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>69,962,500.00</b>	<b>63,855,083.00</b>	<b>(6,107,417.00)</b>	<b>91.27</b>
210501	Эм	0.00	0.00	-	
210502	Хоол хүнс	69,962,500.00	63,855,083.00	(6,107,417.00)	91.27
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл	-	-	-	
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>19,000,000.00</b>	<b>19,000,000.00</b>	<b>-</b>	<b>100.00</b>
210604	Урсгал засвар	19,000,000.00	19,000,000.00	-	100.00



<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр</b>	<b>2,168,500.00</b>	<b>1,905,300.00</b>	<b>(263,200.00)</b>	<b>87.86</b>
210806	мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,168,500.00	1,905,300.00	(263,200.00)	87.86
210807	Газрын төлбөр	0.00	0.00		
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>27,803,500.00</b>	<b>20,136,200.00</b>	<b>(7,667,300.00)</b>	<b>72.42</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,949,100.00	13,281,800.00	(7,667,300.00)	63.40
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,854,400.00	6,854,400.00	-	100.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>6,854,400.00</b>	<b>6,854,400.00</b>	<b>-</b>	<b>100.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>6,854,400.00</b>	<b>6,854,400.00</b>	<b>-</b>	<b>100.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	6,854,400.00	6,854,400.00	-	100.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>-</b>	<b>3,690,900.00</b>	<b>3,690,900.00</b>	
	Бусад хөрөнгө		3,690,900.00	3,690,900.00	
<b>1</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>813,294,100.00</b>	<b>733,244,619.25</b>	<b>(80,049,480.75)</b>	<b>90.16</b>
<b>131</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>767,997,100.00</b>	<b>697,146,200.00</b>	<b>(70,850,900.00)</b>	<b>90.77</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	767,997,100.00	697,146,200.00	(70,850,900.00)	90.77
<b>132</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>45,297,000.00</b>	<b>36,098,419.25</b>	<b>(9,198,580.75)</b>	<b>79.69</b>
132001	Орон нутгийн төсвөөс	45,297,000.00	36,098,419.25	(9,198,580.75)	79.69
<b>31</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>70,850,936.75</b>	<b>70,850,936.75</b>	
<b>31</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>112,085,132.21</b>	<b>112,085,132.21</b>	
<b>1</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>				
<b>2</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1.00</b>	<b>1.00</b>	<b>-</b>	<b>100.00</b>
<b>3</b>	<b>Төсвийн байгууллага</b>	<b>1.00</b>	<b>1.00</b>	<b>-</b>	<b>100.00</b>
	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>23.00</b>	<b>23.00</b>	<b>-</b>	<b>100.00</b>
	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
	Гүйцэтгэх ажилтан	7.00	7.00	-	100.00
	Үйлчлэх ажилтан	14.00	14.00	-	100.00



### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Дархан-Уул аймгийн Дархан сумын 26 дугаар цэцэрлэг нь хамран сургах тойрог буюу 9-р багийн 2-5 насны 166 хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол олгож “Хүүхдийн хөгжлийг дэмжих, суралцахад тулгарч буй бэрхшээлийг арилгах, амжилттай суралцахад бүх талын хамтын ажиллагаа, оролцоог хангаж хичээл, сургалтын үйл ажиллагаа үр дүнтэй зохион байгуулах” гэсэн зорилготой ажиллаж байна.

#### **Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тус цэцэрлэг нь Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Хүүхдийн эрхийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Сангийн сайдын “Аргачлал, зардлын норматив батлах тухай” 2022 оны А/23,27 дугаар тушаал зэргийг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 53 дугаар тогтоол “Хувьсах зардлын хэмжээ, итгэлцүүр, журам батлах тухай”,
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 25 дугаар тогтоол “Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх”,
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 84 дүгээр тогтоол “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай”,
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 82 тоот тогтоол “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох”,
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 104 тоот тогтоол “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн багш ажилтанд мөнгөн тэтгэмж олгох”,
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 237 тоот тогтоол “Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай”,
- Боловсрол, Шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын хамтарсан 2024 оны А/85, А/34 дүгээр тушаал “Орон тооны хязгаарын жишиг норматив батлах тухай”,
- Боловсрол, Шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын хамтарсан 2024 оны 115 тоот дугаар тушаал “Цэцэрлэг, ЕБС-ийн багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх дүгнэх”

Төсвийн шууд захирагч зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан Уул аймгийн Дархан сумын 26 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг газрын даргын 2021 оны А/02 дугаар тушаалаар баталж, мөн оны 01 дүгээр сараас мөрдөж эхэлсэн бөгөөд өөрчлөлт ороогүй, нягтлан бодох бүртгэлийн стандарт, санхүүгийн программтай нийцсэн байна. Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх НББ-ийн журам"-ыг үндэслэн 2025 оноос Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулж мөрдөж ажиллана.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан Уул аймгийн Дархан сумын 26 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нэмэлт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 78,755.3 мянган төгрөгөөр буюу 8.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	70,850.9	112,085.1	41,234.2
Бараа материал	28,269.8	43,718.8	15,449.0
Үндсэн хөрөнгө	879,772.0	901,844.1	22,072.1
<b>Нийт хөрөнгө</b>	<b>978,892.7</b>	<b>1,057,648.0</b>	<b>78,755.3</b>
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	978,892.7	1,057,648.0	78,755.3
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>978,892.7</b>	<b>1,057,648.0</b>	<b>78,755.3</b>

Тайлант жилийн үйл ажиллагааны зардлын хэмнэлт 112,085.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 43,718.8 мянган төгрөг болж 15,449.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 97,811.4 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, үйл ажиллагаанд 82,362.4 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулсныг тайланд бүрэн тусгажээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 901,844.1 мянган төгрөг болж 22,072.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд Дархан сумын ЗДТГазраас 8,340.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж /аяга таваг угаагч/, БШУГазраас багш нарт 15,553.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж /8 ш зөөврийн компьютер/, төсвийн хөрөнгөөр 3,690.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж /өнгөт принтер/ худалдан авч, Орон нутгийн өмчийн газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн А/16 тоот албан бичгийг үндэслэн 23,628.8 мянган төгрөгийн үлдэх өртөггүй хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоож,

дахин үнэлгээгээр 12,523.0 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус бүртгэж, Аймгийн засаг даргын 2024 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 01-А/313 тоот захирамжаар 939,9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 720.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил тус тус акталж данс бүртгэлээс хассантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,057,648.0 мянган төгрөг болж 78,755.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн шууд захирагч 2024 оны төсвийн төсөлд нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 748,481.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 59,709.9 мянган төгрөг нийт 808,191.2 мянган төгрөгөөр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг улсын төсвийг 697,146.2 мянган төгрөг, орон нутгийн төсвийг 45,297.0 төгрөгөөр баталсан байна.

Дээд шатны төсвийн захирагч орон нутгийн төсвийг 14,412.9 мянган төгрөгөөр, улсын төсвийг 51,335.1 мянган төгрөгөөр бууруулж төсвийн саналыг нийт 65,748.0 мянган төгрөгөөр хасаж баталсан. Энэ нь өмнөх онуудын гүйцэтгэлд үндэслэн цалингийн зардлыг 16,440.5 мянган хасаж, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг 22,228.7 мянган нэмэгдэж, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 14,412.9 мянган хасаж, хоол хүнсний зардал 12,331.2 мянган хасаж, бусад зардлыг 44,792.1 мянган төгрөгөөр тус тус бууруулсантай холбоотой байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхдээ улсын төсвөөс 767,997.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 45,297.0 мянган төгрөг нийт 813,294.1 мянган төгрөгөөр бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 45,297.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос 36,098.4 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдсэн 9,198.5 мянган төгрөгийг төвлөрүүлж, улсын төсвөөс 697,146.2 мянган төгрөгийн санхүүжилт, урьд оны үлдэгдэл 70,850.9 мянган төгрөг олгосноос 655,912.0 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдсэн 112,085.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 692,010.4 мянган төгрөг буюу 86,22 хувьтай байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд 112,085.1 мянган төгрөгийн зардлыг тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт

1	<b>71801-Сургуулийн өмнөх боловсрол олгох</b>	<b>813,294.10</b>	<b>692,010.42</b>	<b>(121,283.68)</b>	<b>85.08</b>
1.1	80111- Тогтмол зардал	45,297.00	36,098.42	(9,198.58)	86.97
1.2	80233-Хүүхэд хамгаалал	1,014.50	1,014.50	-	100.00
1.3	81605-Эрүүл мэндийг зардал	2,384.00	1,201.00	(1,183.00)	50.37
1.4	81807-Хоол хүнс	69,962.50	63,855.08	(6,107.41)	91.27
1.5	81816-Хүүхдэд ээлтэй орчин	2,480.50	2,480.50	-	100.00
1.6	81823- Багш, ажилчдын мэргэжил дээшлүүлэх	1,613.00	610.00	(1,003.00)	37.81
1.7	81834-Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	671,835.80	568,292.57	(103,543.22)	84.58
1.8	81835-Боловсролын хэвийн үйл ажиллагааг хангах	18,706.80	18,458.34	(248.45)	98.67

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Ахмад настны тухай хуулийн 14.7-д “Аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр “Ахмадын сан” байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Тайлант онд тус цэцэрлэг нь удирдах 1 ажилтан, гүйцэтгэх 8 ажилтан, үйлчлэх 15 ажилтан буюу нийт 24 ажилтантайгаар ажиллаж, 210901-Бараа үйлчилгээний бусад зардалд 13,281.5 мянган төгрөгийг тус тус зарцуулж, худалдан авах ажиллагаатай холбоотой 21,481.5 мянган төгрөгийн ажил, үйлчилгээ төлөвлөж худалдан авах ажиллагааг зохион байгуулсан ч оролцогч ирээгүй байна.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд нэмэлт санхүүжилт аваагүй байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй.

### **3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Тайлант онд худалдан авах ажиллагааг арван нэгэн удаа харьцуулалтын аргаар зарлаж оролцогч орж ирээгүйн улмаас шууд худалдан авалтыг хийсэн байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дархан Уул аймгийн Дархан сумын 26 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын ахмад настны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “ЦЭСБ-Аудит” ХХК-ийн аудитор Ч.Мөнхбаяр гүйцэтгэж анхан шатны хяналтыг чанарын менежер Т.Эрдэнэтуяа, захирал Ч.Цэрэннадмид, дараагийн шатны хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан Уул аймгийн Дархан сумын 26 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг ЦЭСБ-Аудит ХХК-д 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 03 тоот албан бичгээр ирүүлсэн.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны жилийн эцсийн орлого үр дүнгийн тайлангийн нийт зардал 852,698.8 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 8,527.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Дархан Уул аймгийн Дархан сумын 26 дугаар цэцэрлэгийн 2024 оны төсвийг батлахдаа Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд хуулийг хэрэгжүүлж ажилласан байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 4 шалгуур үзүүлэлтээр шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулбал зохих 171 мэдээллийг бүрэн байршуулсан байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д " Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах ...." гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

##### Шийдвэрлэсэн нь:

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д заасны дагуу “Ахмадын сан” байгуулж, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан “Ахмадын сан байгуулан ажиллах журам”-ын дагуу сангийн хөрөнгийг бүрдүүлж зарцуулан, гүйцэтгэлийг тайлагнаж, хяналт тавьж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Тус газрын 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийхэд илрүүлсэн алдаа, зөрчил гараагүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар зөрчлийг арилгах 528.6 мянган төгрөгийн 1 зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	528.6	1	528.6	100
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>528.6</b>	<b>1</b>	<b>528.6</b>	<b>100</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Боловсролын ерөнхий газрын 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр баталсан 748,481.3 мянган төгрөгийн төсвийн хуваарийг 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр 64,812.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 2024 оны 12 дугаар сарын 28-ны өдөр 64,547.4 мянган төгрөг төвлөрсөн тул харилцах дансны үлдэгдэл буурч төсвийн гүйцэтгэл 83.1% хувьтай гарсан байна. Иймд төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудлыг дараагийн шатны аудитаар шалгаж, шийдэл гаргах нь зүйтэй байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Мөн аудитаар нийт 2,316.0 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрсэн тул зөрчлийг таслан зогсоох 2,316.0 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүллээ.

### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй байна.

### 5.2 Албан шаардлага

5.3.2.1 Илрүүлэлт: Тус цэцэрлэгийн эрхлэгч М.Оюунбаяр Дархан-Уул аймгийн БГ-ын даргын А/141 тоот тушаалаар 2023 оны санхүүгийн тайланд хийгдсэн аудитын дүгнэлтээр “өөрчлөлтгүй” гэж дүгнэгдсэнд нэг сарын цалин 1.5 дахин нэмэгдүүлэн 2,316.0 мянган төгрөгийн балансын урамшуулал авсан нь Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 тогтоолын “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-тай нийцээгүй тул албан шаардлага хүргүүлэв.

### 5.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

Тайлангийн 4.2.2 дахь хэсэгт дурдсан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5<sup>2</sup>-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

<sup>2</sup> Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	/мянган төгрөгөөр/											
	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруулаагүй	Тоо	Дүн	Тоо	Дүн
-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/											
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тус цэцэрлэгийн эрхлэгч М.Оюунбаяр Дархан-Уул аймгийн БГ-ын даргын А/141 тоот тушаалаар 2023 оны санхүүгийн тайланд хийгдсэн аудитын дүгнэлтээр "өөрчлөлтгүй" гэж дүгнэгдсэнд нэг сарын цалин 1.5 дахин нэмэгдүүлэн 2,316.0 мянган төгрөгийн урамшуулал олгосонд албан шаардлага хүргүүлээ.	1	2,316.0	-	-	1	2,316.0	-	-	-	-	-	-
Дүн	1	2,316.0	-	-	1	2,316.0	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал /мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				Зөвлөмж	
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д "Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах ...." гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	1	-	-	-	-	-	1	-
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>